



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХҮРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 1/03

Шивээговь сум

А.Дэлгэрзаяагийн ангилал, зэрэглэл, цалинг
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25-р зүйлийн 25.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Засгийн газрын 2019 оны №21 дүгээр "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" тогтоолын 2.10, Засгийн газрын 2019 оны 275 дугаар "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" тогтоол, Засгийн газрын 2019 оны 472 дугаар "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2, Улсын Их Хурлын хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Албан тушаалын хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам"-ын 3.1, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2012 оны Б/07 тоот "Зэрэг дэв түүний нэмэгдэл олгох тухай" захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга А.Дэлгэрзаяагийн албан тушаалын ангилалыг ТЗ-9-5 дахь шатлалаар тооцон 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн үндсэн цалинг 1045653 /нэг сая дөчин таван мянга зургаан зуун тавин гурав/ төгрөг, хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих /ЭБАТ/-ын нэмэгдэл 11 хувь, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 15 хувь, дэс түшмэлийн тэргүүн зэргийн нэмэгдэл 24 хувийг тус бүр үндсэн цалингаас сар бүр бодож олгохыг нягтлан бодогч /О.Дөлгөөн/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭБАТ